


6.7 Хог ачиж цуглуулах тогтолцоог сайжруулах

6.7.1 Төслийн загвар

а. Үндэслэл

Туршилтын төслийн зорилтод бүс нутаг нь Чингэлтэй дүүргийн 1-6 дугаар хороо буюу орон сууцтай бүх газар нутаг юм. Тэдгээр хороод нь Улаанбаатар хотын худалдааны төв хэсэгт байрладаг бөгөөд Зураг 6-52-д үзүүлснээр оршин суугчдын бүс хэсэг худалдааны байгууллагуудтай холилдон оршиж байна. (Зураг дээрх цэнхэрээр тэмдэглэсэн нь аж ахуй нэгжүүд болон дэлгүүрүүд, улаанаар тэмдэглэсэн нь орон сууцны барилгууд)

Мөн 1-4 дүгээр хорооны орон сууцны олон барилгуудын нэгдүгээр давхар болон байрны подвалийг албан байгууллага, дэлгүүр, хэвлэлийн компани, оёдолчин, ресторан зэрэг жижиг аж ахуй нэгжүүд эзэлдэг бөгөөд тэдгээр жижиг аж ахуй нэгжүүдээс гарах хог хаягдлыг орон сууцнуудын айл өрхөөс гарах хог хаягдалтай хамт ачдаг.



Зураг 6-52: Төслийн хамрагдах хүрээ

2005 оны 9-р сар хүртэл 1-4 дүгээр хорооны ихэнх хэсэг контейнерын тогтолцоотой байхад 5 болон 6 дугаар хорооны өндөр орон сууцуудын айл өрхүүд хогны бункерт хогоо хаяж, хадгалдаг байсан. Контейнерын тогтолцоо нь контейнерын эргэн тойронд хогийн том цэг үүсэх, хог тархах зэрэг олон асуудал үүсгэж байсан тул Чингэлтэй